



# E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Дөрөвдүгээр сар 2017 он

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН НИЙТЛЭГ БАГЦ ДҮРЭМ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ БАЙНА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 16 дугаар тушаалын дагуу Төмөр замын тээврийн тухай хуульд заасан дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулахаар дараах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэж байна:

Дүрэм, журам шинэчлэн боловсруулах IY, YI, VIII, X дэд ажлын хэсгийн 2017.03.31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн Суурь бүтэц ашиглуулах журам, Аюултай байгууламж байрлуулах зайн, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам, Төмөр замын гарал ашиглах журам, Хатуу тооцоот багаж хэрэгслийг ашиглах болон хүлээнлэх журмын төслийг эцэслэн боловсруулж, хурлын тэмдэглэлийн хамтаар ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.

Дээр дурдсан 4 журмын төсөлд санал авах зорилгоор төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын тохируулагч агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага, НЗД, ЦЕГ, Прокурорын байгууллагын харьяа газар, төрийн өмчйт үйлдвэрийн газар, төмөр замын болон төрийн бус 14 байгууллагад албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэж байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ

## АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ БАТЛАВ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.04.03-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн боловсруулсан. “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017.04.19-ний өдрийн A/19 дүгээр тушаалаар батлав.



“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТҮГ



# E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Дөрөвдүгээр сар 2017 он


## ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН ЗУРМАГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИН АЖИЛЛАЖ БАЙНА

Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн тасалдалд шинжилгээ хийж, хяналт тавьж ажилласан.

“УБТЗ” ХНН-ын галт тэрэгний хөдөлгөөний 2017 оны 04-р сарын зурмагийн тасалдалд шинжилгээ хийхэд суудлын галт тэрэгний явуулалтаар тасалдалын тоо 8 нэгж, 78.1 ваг/цаг, өмнөх сартай харьцуулахад 6 нэгж, 58 ваг/цагаар нэмэгдсэн. Суудлын галт тэрэгний өнгөрүүлэлтээр тасалдалын тоо 16 нэгж, 174.4 ваг/цаг, өмнөх сартай харьцуулахад 1 нэгж, 29.9 ваг/цагаар нэмэгдсэн. Ачааны галт тэрэгний явуулалтаар тасалдалын тоо 19 нэгж, 1135 ваг/цаг, өмнөх сартай харьцуулахад тасалдал хэвэндээ, 312.1 ваг/цагаар нэмэгдсэн. Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтээр тасалдалын тоо 73 нэгж, 6380.3 ваг/цаг, өмнөх сартай харьцуулахад 26 нэгж, 3481 ваг/цагаар нэмэгдсэн байна. Нийт тасалдалын өрөнхий дүн 116 нэгж, 7767.8 ваг/цаг бөгөөд өмнөх сартай харьцуулбал тасалдал 33 нэгжээр, 3881 ваг/цагаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2017.04						
Сар	Нэгж	Суудлын галт тэрэгний явуулалт	Суудлын галт тэрэгний өнгөрүүлэлтээр	Ачааны галт тэрэгний явуулалт	Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтээр	Нийт
III	тасалдал	2	15	19	47	83
	ваг/цаг	20.1	144.5	822.9	2899	3886.5
IV	тасалдал	8	16	19	73	116
	ваг/цаг	78.1	174.4	1135	6380.3	7767.8
зөрүү	тасалдал	6	1	0	26	33
	ваг/цаг	58	29.9	312.1	3481	3881

### Тасалдал



“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ



# E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Дөрөвдүгээр сар 2017 он

## БНХАУ-ЫН ТӨМӨР ЗАМ БАРИХ, ШИНЭЧЛЭХ ҮЕИЙН ТӨССӨВ ЗОХИОХ АРГАЧЛАЛ, НОРМ ДҮРМИЙН ОРЧУУЛГА ХИЙВ

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний 3.17-д тусгай захиалгат бүтээгдэхүүнээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, “Төмөр зам барих, шинэчлэх үеийн төсөв зохиох аргачлал, норм дүрэм” 150 хуудас баримт бичгийг хятад хэлнээс орчууллаа.

Төмөр замын дэд бүтцийн зураг төслийн төсөв боловсруулах аргачлал, зардал бүрдүүлэлт, тооцооллын стандартыг нэгдмэл болгохын тулд төрийн болон төмөр замын холбогдох дүрэм, журам, төмөр замын дэд бүтцийн онцлогийг харгалзан энэхүү аргачлалыг боловсруулсан.

Уг аргачлал нь төмөр замын дэд бүтцийн дунд болон том хэмжээтэй төслийн зураг төслийн төсөв зохиох үндэс болдог. Төсөв боловсруулахад энэхүү аргачлалыг баримтлахын зэрэгцээ барилгын төслийн нөхцөл байдалтай уялдуулан үнэн зөв, хатуу хяналтад дор хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах зарчмыг баримтлах ёстой.

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн инженерийн зэрэг олгох, сунгах сургалтад хамрагдсан зэрэг горилогч нараас мэргэжлийн шалгалт авах комиссыг мэргэжилтний мэргэжлийн орон тооны бус зөвлөлийн даргын тушаалаар байгуулж, 2017.04.21-ний өдөр зэрэг горилогч нараас мэргэжлийн шалгалт авах ажлыг зохион байгуулав. Тус сургалтад төвийн хоёр ажилтан амжилттай хамрагдаж төгссөн.

## ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДАГУУ ТӨВИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САР БҮР МЭДЭЭЛЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Үр дүнгийн гэрээний 3.9-т тусгагдсан ажлын хүрээнд Шилэн дансны тухай болон Төсвийн тухай хуулийн тогтоомжийг хэрэгжүүлж, тайлан мэдээг хугацаанд нь байршуулж ажиллаж байна. 4 дүгээр сард тухай бүр байршуулах 8, сар бүр байршуулах 3 нийт 11 мэдээлэл байршуулсан.

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ		ТАСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ЯМ	АГЕНТЛАГ	ТОРIFIН СОМЧИТ АЖАХИЙН ГЕЛЖ		
1	Дараа жилийн тасвийн төслийн (Бүтэн жилээр)				—	—	
2	Тасвийн байгуулалын багтадсан төслийн, гүйцэтгэх, хэрэгжүүлж хамгаалалтад тайлбан тайланыг хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Утиргал бүр, Сар бүр)				✓	✗	
3	Тухайн жилийн тасвийн орсон наамж, берилжлэлт (Тухай бүр)	ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ Төсвийн ерөнхийлөн захирагч: Зан. Тээврийн хөгжлийн Сайд Доржтэн Төнөрбаттар Ариунбаттар Нийтийн бодлогын Сандийнэвтрээний Сайд					
4	Өмнөх оны тасвийн зарлагын хамгамт, туслах уйл ажиллагааны орлогос дэвсэн хасгийн урамшуулалт зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Угас: 77244400 Угас: 77244409					
5	Хандив, туслахийн замжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨНӨР, ХУДАИДАН АВАЛТ					
6	Цалингийн зардлас бусад таван сал төгрөгөөс дээш үүйн дун бүхий орлог, зарлагын иянгэн гүйгээ (Тухай бүр)	2017 1 сар 2017 2 сар 2017 3 сар 2017 1-р улирал 2017 4 сар					
		✓	✗	✓	—	✓	

“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ



# E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Дөрөвдүгээр сар 2017 он

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ



УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтооюур батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах ажил зохион байгуулах ажлын хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг төвийн хэмжээнд сурталчлан таниулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулаа.

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦЛОО

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг 5 төрөлт спортын тэмцээнд “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТУГ-ын хамт олон амжилттай оролцож боулингийн төрөлд хүрэл медаль хүртлээ. Зам, тээврийн салбарын спортын шилдгүүдээ тодруулдаг тэмцээнийг өнгөрсөн жил “МИАТ” ТӨХК зохион байгуулж байсан бол энэ жил ИНЕГ хариуцан зохион байгууллаа.

Идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа хөгжүүлэн чийрэгжүүлэх, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, биеийн тамир, спортом ажилтан, албан хаагчдыг идэвхтэй оролцуулах, яамны харьяа байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг уламжлалт тэмцээн ийнхүү амжилттай өндөрлөлөө.



“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ